

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2017 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**“Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах,  
санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх,  
зарцуулах журам”-ыг шинэчлэн батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 21.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 337 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2017 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн  
... дүгээр тогтоолын хавсралт

## **ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ДАНС БАЙРШУУЛАХ, САНГИЙН ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ**

### **НЭГ.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэхүү журмын зорилго нь жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн данс /цаашид “данс” гэх/ байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### **ХОЁР.Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийн эх үүсвэр**

2.1.Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.1-д заасан “жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгө”-ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан шийдвэрээр тооцно.

2.2.Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.2-т заасан “Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн торгуулийн орлогын 50 хувь”, 22.1.4-т заасан “автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь” эх үүсвэрийг санхүү төсвийн, болон авто замын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран баталсан сангийн дансанд шилжүүлэх журмаар тооцно.

2.3.Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.5-д заасан “мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого;” эх үүсвэрийг Албан журмын даатгагчдын холбооноос /цаашид “Холбоо” гэх/ мэдээллийг ашиглуулах журам, үйлчилгээний хөлсний хэмжээгээр тооцно.

2.4.Сангийн хөрөнгө хүрэлцэхгүй болсон тохиолдолд холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр холбооны гишүүн даатгагчаас хөрөнгө төвлөрүүлнэ.

2.5.Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.3-т заасан буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлнэ. ~~Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн/~~

### **ГУРАВ.Сангийн данс байршуулах, харилцагч банкныг сонгох**

3.1. Холбоо нь сангийн данс байршуулах, орлого төвлөрүүлэх бэлэн мөнгөний төлбөр тооцоог гүйцэтгэх 3-аас доошгүй харилцагч банкныг сонгон шалгаруулна. ~~Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 233 дугаар тогтоолоор оорчлон найруулсан/~~

3.2.Холбоо харилцагч банкныг сонгохдоо дараахь шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ:

3.2.1.Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 жилийн байдлаар хангасан;

3.2.2.санхүүгийн хувьд тогтвортой, найдвартай үйлчилгээг тогтмол үзүүлэх боломжтой;

3.2.3.сангийн үйлчилгээ авах шаардлагатай газар бүрт үйлчлүүлэгч нарт үйлчлэх боломжтой;

3.2.4.харьцангуй бага шимтгэлтэй үйлчилгээг үзүүлэх чадвартай;

3.2.5.түргэн шуурхай, тохиромжтой үйлчилгээг үйлчлүүлэгч нарт үзүүлэх чадвартай.

3.3.Холбоо сонгон шалгаруулалтад шалгарсан харилцагч банктай гэрээ байгуулна.

3.4.Холбоо нь сонгон шалгаруулсан харилцагч банктай байгуулсан гэрээний хэрэгжилтийг улирал тутам дүгнэж, аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэнэ.

3.5.Харилцагч банкны үйлчилгээ хангалтгүй, энэ журмын 3.3-д заасан шалгуурыг хангаагүй гэж үзсэн тохиолдолд харилцагч банктай байгуулсан гэрээг цуцалж, харилцагч банкныг дахин сонгон шалгаруулна.

3.6.Холбоо нь шалгаруулалтанд тэнцээгүй харилцагч банкинд данс нээхийг хориглоно.

3.7.Сангийн хөрөнгийг дараах хэлбэрээр байршуулж болно.

Үүнд: Хөрөнгө байршуулах/нэгжид ногдох дээд хувь

3.7.1.Засгийн газрын бонд, баталгаат үнэт цаас 100,0/50,0

3.7.2.Банкны хадгаламжийн сертификат 20,0/5,0

3.7.3.Банкны харилцах хадгаламж 100,0/33,4

3.7.4.Хорооноос зөвшөөрсөн бусад хөрөнгө оруулалт

3.8.Хөрөнгө байршуулах хэмжээг тооцохдоо нийт хөрөнгийн дүнг харгалзан хөрөнгө байршуулах хувиар үржүүлж тооцно.

### **ДӨРӨВ.Сангийн зарцуулалт**

4.1.Сангийн хөрөнгийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу зарцуулна.

4.2.Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1.1-т заасны дагуу нөхөн төлбөр олгохдоо дараах баримтуудаар баталгаажуулсан байна.

4.2.1.даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан үед Холбооны жолоочийн даатгалын мэдээллийн сангийн тодорхойлолт;

4.2.2.бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус үед мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, акт, шийдвэр;

4.2.3.даатгагч дампуурсан тохиолдолд Хорооноос гаргасан тодорхойлолт, мэдэгдэл;

4.2.4.хохирогч болон буруутай этгээдийн өргөдөл;*Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн.*

4.2.5.иргэний болон жолооны үнэмлэхний хуулбар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар; *Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн.*

4.2.6.даатгалын тохиолдол болсныг нотолсон баримт бичиг; *Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн.*

4.2.7. нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосон хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт; ~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн./~~

4.2.8. нөхөн төлбөр олгохтой холбоотой бусад шаардлагатай баримт бичиг; ~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн./~~

4.2.9. хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээ буцаан нэхэмжлэх эрхийг Жолоочийн даатгалын санд шилжүүлэх гэрээг хохирогчтой байгуулж, нотариатаар баталгаажуулсан байна; ~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн./~~

~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 366 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

4.2.10. гэм буруутай этгээдтэй нөхөн төлбөрийг буцаан барагдуулах талаар гэрээ байгуулж, нотариатаар баталгаажуулсан байна. ~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн./~~

~~/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 366 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

4.3. Нөхөн төлбөр олгох нарийвчилсан зааврын төслийг Холбоо боловсруулж Хороогоор батлуулна.

4.4. Холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1.2, 23.1.3, 23.1.4-т заасан зориулалт тус бүрийн зарцуулах хөрөнгийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлж хянуулсны дараа Холбоо нь төсвийн төслийг хэлэлцэж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор батална. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор оорчлон найруулсан./~~

4.5. Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1-т зааснаас өөр зориулалтаар сангаас хөрөнгө зарцуулахыг хориглоно. Сангаас гарах зардлыг санхүүжүүлэхтэй холбогдсон анхан шатны баримт нь үнэн зөв, бодит тоон мэдээнд үндэслэгдсэн байна. Санхүүгийн тайланд гарсан аливаа алдааг залруулах бол холбогдох нэмэлт баримт бүрдүүлэн залруулга хийж, зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

4.6. Зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээж авсан ажилтан хариуцна.

4.7. Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1.4-т заасан сургалт сурталчилгааг санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрднө. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 233 дугаар тогтоолоор оорчлон найруулсан./~~ ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 172 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

4.8. Энэхүү журмын 4.2.9-д заасан гэрээнд хохирогч өөрөө буруутай болох нь тогтоогдвол авсан нөхөн төлбөрийг үл маргах журмаар буцаан Жолоочийн даатгалын санд шилжүүлэхийг туегана. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн./~~

~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 366 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

4.9. Энэхүү журмын 4.2.9-д заасан гэрээнд хохирогч нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үйл явцад Жолоочийн даатгалын сантай хамтран ажиллах талаар туегасан

~~байна. /Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн/~~

~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02 ны өдрийн 366 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./~~

4.10. Жолоочийн даатгалын сан нь хохирлын үнэлгээг дахин хянан үзэж, хохирогч болон буруутай этгээдээс нэмэлт мэдээлэл шаардана. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн/~~

4.11. Даатгалын хохирол үнэлэгчийн тогтоосон хохирлын үнэлгээг буруутай этгээд, хохирогч, жолоочийн даатгалын сангийн аль нэг тал нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд өөр даатгалын хохирол үнэлгээний байгууллагаар өөрийн зардлаар дахин нэг удаа хийлгэж болно. Дахин хийлгэсэн үнэлгээ, анхны үнэлгээний дүн зөрүүтэй байвал аль бага үнэлгээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн/~~

4.12. Жолоочийн даатгалын сан нь хохирогчид нөхөн төлбөр төлөх үндэслэлгүй гэж үзвэл албан бичгээр хариу мэдэгдэнэ. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн/~~

4.13. Даатгагч нь даатгалын гэрээний мэдээгээ жолоочийн даатгалын мэдээллийн санд ирүүлээгүйгээс жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тохиолдолд тухайн даатгагчаас нөхөн төлбөрийг буцаан нэхэмжилнэ. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 381 дүгээр тогтоолоор нэмсэн/~~

4.14. Жолоочийн даатгалын сан нь “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийн 20.2-д заасны дагуу олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс барагдуулах арга хэмжээ авч, шүүхэд нэхэмжлэл гаргана. ~~/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 02 ны өдрийн 366 дугаар тогтоолоор оорчлон найруулсан./~~

## **ТАВ.Хяналт, хариуцлага**

5.1. Холбоо нь сангийн бүрдүүлэлт, зарцуулалтай холбоотой дараах эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Сангийн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөнд хяналт тавих;

5.1.2. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлүүлэх;

5.1.3. Даатгалын нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардаж авах;

5.1.4. Даатгагч нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 19.2-г зааснаас бусад тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ, даатгуулагчийн гэм бурууг тогтоосны дараа гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргээс даатгалын гэрээнд заасан хэмжээгээр даатгуулагчийг чөлөөлөх.

5.2. Холбоо нь сангийн бүрдүүлэлт, зарцуулалтай холбоотой дараах үүргийг гүйцэтгэнэ:

5.2.1. Даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авсан даруйд даатгалын тохиолдол болсон газарт шуурхай албаны төлөөлөгчөө илгээх;

5.2.2. Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, сан хариуцах;

5.2.3. Сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах;

- 5.2.4. Даатгагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг дансанд төвлөрүүлэх;
- 5.2.5. Сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Хороонд тайлагнах;
- 5.2.6. Сангийн бүрдүүлэлтэд хяналт тавих, зарцуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороогоор батлуулах;
- 5.2.7. Сангийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг даатгагч нарт хүргүүлэх;
- 5.2.8. Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх;
- 5.2.9. Сангийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод явуулах;
- 5.2.10. Сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах;
- 5.2.11. Сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх;
- 5.2.12. Жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх бөгөөд аудит хийх компанийг даатгалын байгууллагын аудитын эрх авсан, сүүлийн 2-оос доошгүй жилд даатгалын компанид аудит хийсэн туршлагатай 3 компаниас сонгоно;
- 5.2.13. Хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх;
- 5.2.14. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

### **ЗУРГАА. Хорооны үүрэг**

- 6.1. Хороо нь сангийн санхүүгийн тайланг улирал тутам хянаж, тайлангийн хариуг албан бичгээр хүргүүлнэ.
- 6.2. Хороо нь жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан газар дээрх хяналт шалгалтыг хийж, шалгалтын тайланг удирдлагад танилцуулна.

### **ДОЛОО. Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага**

- 7.1. Сангийн хөрөнгийг зарцуулах, зарцуулалтанд хяналт тавих тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.